

22. Норвеги эмэгтэйчүүдийн зүрх сэтгэлийг нээгээч, Эзэн минь, танд итгэж, таны хайр, сайхан сэтгэлийг хүлээн авах болтугай. Тэд ичгүүр, гэм буруу, татгалзсан мэдрэмжээ хаяж, таны хайр, халамж, өршөөл, эдгэрлийг хүлээн авах болтугай. (Ром 8:1)

23. Аав аа, Франц дахь оюутнуудын оюун ухаан, зүрх сэтгэлийг хамгаалахын төлөө бид залбирч байна. Суралцагч бүр өөрийн үнэ цэнэ, хувь хүний байдлаа таны үнэнээс бас хайраас олох болтугай. (Дуу. 100:3)

24. Сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн Итали эмэгтэйчүүдийг эдгээхийн төлөө залбирч байна. Аав аа, дайсны гинжийг тасалж, эдгээр эмэгтэйчүүдэд таны үгэнд хоргодож зүрх сэтгэлээ эдгээж, бие мах бодийхон хувьд тэдэнд хэрэгтэй зөв эмчилгээ хийхэд нь туслаач. (Иохан 8:32)

25. Нидерланд дахь Христийн шашны сургуулиуд 100 гаруй жилийн турш засгийн газраас санхүүжилт авч байгаад баярлалаа, Эзэн минь. Тэд таны Библийн үнэнийг зааж, хүлээн зөвшөөрөх газар хэвээр байх болтугай. (Тит 2:1)

26. Эзэн минь, Бид Танд Фарерын арлуудын 50,000 оршин суугчдыг, танилцуулж байна. Хэдийгээр тэд 18 арал дээр тархсан ч хүмүүст нийгэм, эв нэгдлийн мэдрэмжийг авчирч байгаад талархаж байна. (Кол. 3:14)

27. Орос эмэгтэйчүүдийг “Найдвар доторх Эмэгтэйчүүд” хөтөлбөрт оролцуулж, тэдний шархалсан зүрх сэтгэлийг эдгээхийг хүсдэг Тэнгэрлэг Эцэгийг олоосой гэж би залбирч байна. (Дуу. 34:18).

28. Швейцарь дахь залуу итгэгчид өөрсдийгөө Христийн шашинд зориулахад бэлэн байгаад бид Бурхандаа талархаж байна. Тэд тантай харилцах харилцаагаа улам гүнзгийрүүлэх болтугай. (1 Петр 2:2)

29. Аав аа, Босни Герцеговинагийн ард түмэн эвлэрч, эв найрамдалтай байгаасай гэж танаас гуйж байна. Улс орныхоо удирдагчид эх орныхоо төлөө зөв шийдвэр гаргахад нь мэргэн ухаан хайрлаач. (Ром. 12:18)

30. Бурхан минь, залуучууд шашнаасаа татгалзаж байгааг та харж байгаа. Бүгд Найрамдах Чех улсын залуучууд Есүс Христийг Аврагч, Эзэн гэж хүлээн аван, тэнд шинэ итгэгчдэд улам идүү өсөх болтугай. (Ном. 12:1)

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다



Найдвартай
ЭМЭГТЭЙЧҮҮД

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанлиг
100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа
залбирч байна.



2022. 4.

SEMENA дахь эмэгтэйчүүдэд зориулсан залбирал

Бид SEMENA бүс нутагт оршдог CAMENA тосгонд амьдардаг эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. SEMENA нь Төв Азийн Ойрхи Дорноддох, Хойд Африкийн бүс нутагт оршдог газар нутаг юм. Харин CAMENA тосгон нь TWR-байгууллагийн өгсөн товчлолт нэр юм. Энэ газар нутагт Христийн шашинтай байх нь хууль бус байдаг бөгөөд хамтдаа залбирч, цугларах юм бол тэднийг баривчилж, байцааж, шоронд хийдэг. CAMENA орчмын олон эмэгтэйчүүд өөрсдийгөө ямарч үнэ цэнэгүй гэж боддог. "Найдвар доторх Эмэгтэйчүүд" хөтөлбөрөөр дамжуулан тэдэнд мэдлэг, итгэл, тайтгарал, Бурханд итгэх итгэлийг олж авах болтугай гэж бид залбирч байна.

TWR Korea 북방선교방송

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Эзэн минь, TWR-ийн "Найдвар Доторх Эмэгтэйчүүд" инстаграм хуудсыг дагаж байдаг олон орос эмэгтэйчүүдэд үргүйдлийнхээ төлөө залбиран гуйж байна. Та тэдэнд сэтгэл санааны болон бие махбодийн эдгэрэлийг өгөөч. (Дуу. 119:76)

2. Аав аа, та Албани дахь бэлэвсэн эмэгтэйчүүдийг бусад хүмүүстэй зэрэгцүүлэн сүнсээр урамшуулж, сэтгэл санааг нь тайвшруулж, эдийн засгийн болон эрх чөлөөгөө олж авахад нь туслаач! (Дуу. 68:5)

3. Бурхан минь, Дани улс дахь итгэгчдэд сэргэлтийг авчираач. Таны үгийг өдөр бүр уншиж, танруу хандан залбирах хэрэгтэй гэдгийг тэдэнд ойлгуулаач. Эжүүд, эмээ нар хүүхдүүд, ач зээ нарынхаа зүрх сэтгэл болон амьдралд нь таныг дамжуулах ёстой элч нь юм гэдгийн тэдний оюун санаанд ухааруулаач. (Сургаалт үгс 7:1-3)

4. Эзэн минь, Италд дүрвэгсд болон оргонолын харьяалалд хамрагдаж буй эмэгтэйчүүд маш их өвдөлтийг мэдэрч байна. Эрх баригчдад тэдний эмнэлгийн тусламж, сэтгэл зүйн болон хууль зүйн үйлчилгээ авах хэрэгцээг олж харж, зохих арга хэмжээ авахад нь туслаач. (Дуу. 56:8).

5. Ганцаардлын улмаас олон залуу Швед охид интернетэд маш их цаг зарцуулж байна. Аав аа, бид тэдний сэтгэл санаа, бие махбодийн болон сүнслэг байдлын төлөө залбирч байна. Тэд хүчирхийлэл болон дээрэмийн золиос болох ёсгүй. (Сургаалт үгс 4:23).

6. Бурхан минь ээ, эмэгтэйчүүдийн оюун санааны амьдралд өөрчлөлт хийж нөлөөлж чадахаар Сербийн багт асар их бүтээлч сэтгэлгээг өгөөч. "Найдвар доторх Эмэгтэйчүүд"-ийн залбирлын хуанли ашиглана залбирч, үгийг тань унших замаар маш олон эмэгтэйчүүд таньруу ирэх болтугай. (Еф. 4:15)

7. Норвеги дахь Христэд итгэгч эмэгтэйчүүдийг сэргээгээч, Эзэн минь ээ. Тэдний завгүй амьдарлын хэмнэлийг удаашруулж, тангай хамт байх цаг гарган, залбирч үгийг тань унших болтугай! (Матай 6:33)

8. Аав аа, Гренландад бэлгийн хүчирхийлэл, цус ойртолтод өртсөн охид хөвгүүдийг эдгэрэхийн төлөө бид залбирч байна. Үр хүүхдээ хүндэлж, хайрлаж, халамжлахын тулд аав, ээжийн амьдралд ч бас зүтгэ. (Еф. 6:4)

9. Францын нийгэмд орон нутгийн христийн радиогийн нөлөөлөл улам бүр нэмэгдэж байгаад Бурханаа магтъя. 1981 оноос хойш тус станцууд үндэстнийг эерэг хандалгаруу чиглүүлж, сайн мэдээг түгээх зорилгоор олширчээ. (Еф. 3:20–21)

10. Эзэн минь, бид 5-р сард болох Германы хүний наймааны эсрэг конгресс дээр "Нуугдсан Эрдэнэсүүд" аудио цуврал нэвтрүүлэгийг маань эерэгээр хүлээн авахын төлөө залбирч байна. Нийгмийн ажилтан, байгууллагууд энэхүү цуврал нэвтрүүлгийг авч ажилчиддаа болон хүмүүстээ сонсоход нь зөвшөөрөөч. (Матай 13:44)

11. Аав аа, Нидерландын шинэ засгийн газар, ялангуяа итгэгч гишүүдэд урам зориг, мэргэн ухаан хайрлаач. Тэд нийгмийн эрүүл мэнд, орон сууц, эмнэлгийн ёс зүйн талаар чухал шийдвэр гаргахдаа таниас удирдамж аван ажиллах болтугай. (Дуу. 72:1–20)

12. Бурхан минь, Болгарын цыган эмэгтэйчүүдийн зүрх сэтгэлийг өөрийн авралынхан төлөө чиглүүлээч, мөн гэр бүлээ өсгөх мэргэн ухааныг өгөөч. Тэдэнд тулгарч буй нийгмийн болон боловсролын саад бэрхшээлийг даван туулахад нь тусалаач. (Лук 18:27)

13. Финлянд дахь манай түншийн ивээн тэтгэгдэг "Найдвар доторх Эмэгтэйчүүд" хөтөлбөрийг дэмжих зорилгоор Финлянд, Шведийн Лютеран нийгэмлэгүүдээс цуглуулсан 3-р сарын өргөлийн төлөө Бурхан Таныг бид магтъя. (Лук 6:38)

14. Аав аа, та биднийг сүнсний хувьд ч махан биений хувьд ч тэжээгч минь билээ. Хорватын эмэгтэйчүүдийг гэр бүлээ тэжээхийн тулд сайн нөхцөл боломжтой ажлын байраар хангаач. Тэд таньруу хандан харах бүрдээ урам зоригтой, итгэлтэй байх болтугай. (Филиппой 4:19)

15. Бурхан минь, Португалийн TWR-ийн "Найдвар доторх Эмэгтэйчүүд" багийнханд баярлалаа. Португалийн эмэгтэйчүүдэд үйлчлэхэд шаардлагатай хөрөнгө мөнгө болон нэмэлт багийн гишүүдийг цуглуулж чиглүүлэхдээ энэ багт зүрх сэтгэл, алсын харааны нэгдмэл байдлыг өгөөч. (Филиппой 2:2)

16. Эзэн минь, Фарерын арлуудад амьдардаг бусад орны эмэгтэйчүүдийг нийгэмд хүлээн зөвшөөрөөсэй гэж бид залбирч байна. Эдгээр гэр бүлүүдэд Христийн итгэл найдварыг авчираач. (Ег. 23:9).

17. Аав аа, Румынд COVID-19-ийн халдвар авсан гэр бүлүүдэд хоол хүнс, хэрэгцээт зүйлс, мөн Бурханы хайрыг түгээж, зөвлөгөө өгдөг эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлээч. Хайртай хүмүүсийнхээ төлөө гашуудаж буй тэдгээр хүмүүс таны тайвшралыг олж авах болтугай. (Иохан 11:25)

18. Цар тахлын улмаас Испанид олон хүн тусгаарлагдаж, ганцаардаж, даван туулахад хүнд уй гашуунд байна. Тэдгээр хүмүүс Бүх ертөнцийн Эзэн таны тухай мэдэх болтугай гэж бид залбирч байна. (Иохан 14:27)

19. Эзэн минь, Швейцарийн ард түмэн Христийн шашны талаар сонирхож байна, тэд үнэний тухай судалж, таныг хайх тэр замууд нв саадгүй нээлттэй байж, танд итгэх болтугай гэж бид залбирч байна. (Ис. 26:9)

20. Аав аа, бид эмэгтэйчүүдийг бараа шиг худалддаг зуучлагч нар болон бусад хүмүүсийн зүрх сэтгэлийн төлөө залбирч байна. Тэдний зүрх сэтгэлийг бузар муугаас хол байлгаж, танд итгэн, амар тайван шинэ амьдрал руу эргэхэд нь ятгаач. (Исаиа 1:16).

21. Эзэн минь ээ, Албанийн шоронд эмэгтэйчүүдэд үйлчилдэг бүх хүмүүст мэргэн ухаан, нигүүлсэлийг хайрлаач. Шоронд хоригдсон эмэгтэйчүүдэд Есүст итгэх итгэл найдвар олоход нь тусалдаг Shkbsb зэрэг Христийн шашны байгууллагуудад баярлалаа. (Евр. 13:3).